

**"АПУ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 22/01
Улаанбаатар хот

АПУ ХК (цаашид "Компани" гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04-р сарын 29-ний өдрийн 14 цаг 15 минутад эхлэв.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэд мэндчилгээ дэвшүүлж, тус хуралд БиДиСек ҮЦК ХК-ийн хөгжүүлсэн бүртгэл, санал хураалтын програмыг ашиглаж байгааг дурдаад, хурлаар хэлэлцэх асуудал болон хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулахаар ирсэн зочдыг танилцуулав. Үүнд:

Хэлэлцэх асуудал:

1. АПУ ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох;
3. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох

Хуралд оролцсон:

1. ТУЗ-ийн хараат бус гишүүн Ё.Гэрэлчулуун
2. ТУЗ-ийн хараат бус гишүүн О.Одбаяр
3. ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Үнэнбат
4. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан
5. Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг
6. Санхүү эрхэлсэн захирал Г.Энхбилэг
7. Хөндлөнгийн аудитор KPMG Audit LLC Татьяна Яковлева
8. Хөндлөнгийн аудитор KPMG Audit LLC Г.Эрдэнэбаяр

Улмаар хурлын тооллогын комиссын дарга Б.Ононг хурлын ирцийн мэдээг танилцуулна уу хэмээн индэрт урив.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга Б.Ононгийн танилцуулснаар:

Компанийн 1,002,733,872 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 180 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байгаа нь нийт саналын эрхтэй 1,062,974,743 ширхэг энгийн хувьцааны 94.33% болж байна. Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дахь заалт, Компанийн Дүрмийн 7-р зүйлийн 7.11-д заасныг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Ирц бүрдсэн тул АПУ ХК-ийн гүйцэтгэх захирал, хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хурлыг нээж, эхний хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах

Танилцуулсан нь:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулахдаа дараах зүйлсийг онцлон тэмдэглэв:

- GS25 сүлжээ дэлгүүрийн үйл ажиллагаа эрхэлж буй Дижитал Концепт ХХК-ийн хувьцаа эзэмшигч болсноор АПУ группийн бүтцэд хараат компани нэмэгдсэн.
- Гүйцэтгэх удирдлагын багт 4 залуу захирал шинээр томилогдон ажиллаж байна.
- Цэвэр борлуулалтын орлого 38%, борлуулалтын тоо хэмжээ 22%, бүтээгдэхүүний нэр төрөл 5%, цэвэр ашиг 73%, татвар төлөлт 38% (365 тэрбум төгрөг) өссөн бол ажилтны тоонд өөрчлөлт гараагүй, бүтээмжийг дээшлүүлэн ажилласан.
- Хувьцаат компанийн томоохон үзүүлэлт бол зах зээлийн үнэлгээ бөгөөд өнгөрөгч онд 1 их наядаар үнэлэгдсэн Монголын анхны компани болсон. Компаниас хувьцааны ханшид нөлөөлөх арга хэмжээ авдаггүй, органик өсөлтөөр энэ үнэлгээнд хүрсэн.
- Экспортыг нэмэгдүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байгаа ба ОХУ-ын борлуулалт 220%, БНХАУ борлуулалт 440%-аар тус тус өссөн.
- GS25-д хөрөнгө оруулсан нэг зорилго болох тус сүлжээ дэлгүүрийн сувгийг ашиглан 14,000 орчим дэлгүүрээр АПУ компанийн бүтээгдэхүүнийг борлуулах боломж бүрдсэн.
- Компани хүн төвтэй засаглалын бодлогыг эргэлт буцалтгүй сонгож, үйл ажиллагаа явуулж байна. 2021 онд нийт 2017 ажилтантай (63.7% эрэгтэй, 36.3% эмэгтэй) үйл ажиллагаа явуулж, Ковид цар тахлын үед эрүүл мэндийг дэмжих бүхий л ажиллагааг авч хэрэгжүүлсний дүнд үйлдвэрлэл, борлуулалтаа тасралтгүй явуулж чадсан.
- Эрсдэлийн хувьд компанийн үйл ажиллагааны онцлог бол хууль эрх зүйн орчин бөгөөд салбарын үйлдвэрлэгч, төлөөлөгчдийг хууль боловсруулах үйл явцад оролцуулж, санал авч байгаа нь талархууштай явдал болж байна.
- Компани дэлхийн 20 орчим улсаас түүхий эд, сав баглаа, материал татан авдаг ба хил гаалийн хүндрэл томоохон асуудал болж байгаа ч дэс дараатай арга хэмжээ авч ажилласан.
- Тогтвортой хөгжлийн бодлогыг хөндлөнгийн мэргэжилтний тусламжтай чамгүй сайн боловсруулж, олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тэдгээрээс “Соёлоор гоёно”, “Шилээ дахин амьдруулъя” төсөл ихээхэн ач холбогдолтой.
- Хөрөнгө оруулагчид хувьцааны ханшийн өсөлт (2021 оны эхэнтэй харьцуулахад оны эцэст хувьцааны ханш 3 дахин нэмэгдсэн) болон ногдол ашиг (2021 оны нийлбэр дүнгээр нэгж хувьцаанд 106 төг)-аас өгөөж хүртлээ.

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ё.Гэрэлчулуун: ТУЗ-ийн 2021 оны ажлын товч тайлан, 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулахдаа доорх зүйлсийг онцоллоо:

- ТУЗ 9 гишүүнтэй, 8 нь эрэгтэй, 1 нь эмэгтэй, 5 нь Монгол, 4 нь гадаад гишүүн (Сингапур улсын иргэн 2, ОХУ-ын иргэн 1, АНУ-ын иргэн 1) байна.
- ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, дотоод бодлого, дүрэм журамд заасан АПУ ХК-ийн ТУЗ-ийн болон түүний охин, хараат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлдэг.
- Өнгөрөгч онд ТУЗ 9 удаа, тус бүр 100%-ийн ирцтэйгээр хуралдаж, бүрэн эрхийнхээ хүрэнд 40 тогтоол шийдвэр гаргасан. Эдгээр шийдвэрүүд нь Компанийн бизнес төлөвлөгөө, жил, хагас жил, улирлын үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэн батлах, бусад тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхтэй холбоотой байв. Мөн ашиг орлогыг нэмэгдүүлэх, Компанийн удирдлага, зохион байгуулалтыг шинэчлэн өөрчлөх асуудлууд анхаарлын төвд байлаа.
- ТУЗ-ийн дэргэд Аудит, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын гэсэн 3 дэд хороо ажиллаж, Аудитын хороо 2 удаа, Нэр дэвшүүлэх хороо 1 удаа, Цалин урамшууллын хороо 1 удаа хуралдан, хариуцсан чиг үүргийнхээ хүрээнд санал, шийдвэр, дүгнэлт гарган ажиллав.
- ТУЗ Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар “АПУ групп компани 2021 онд тавьсан зорилтуудаа бүрэн биелүүлж, амжилттай ажилласан” хэмээн дүгнэсэн.
- ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд хуульд заасан нэмэлт үүргийн дагуу ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, шийдвэр хууль тогтоомж болон Компанийн эрх ашигт бүрэн нийцэж байгааг мэдэгдье.
- 2021 оны үйл ажиллагаанаас “1. Ковид-19 цар тахлын хүнд үед эрсдэлийн менежментийг маш оновчтой зохион байгуулсны үр дүнд санхүү, үйл ажиллагааны бүх үзүүлэлтийг өсгөж чадсан, 2. Компанийн засаглалыг сайжруулах, ил тод, ойлгомжтой санхүү, бүртгэл хяналтын тогтолцоог бүрдүүлэх талаар Гүйцэтгэх удирдлага идэвх санаачилгатай ажиллаж байна, 3. Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, ялангуяа сүү, сүүн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, инноваци, ногоон хөгжлийг дэмжих чиглэлээр олон арга хэмжээ авч ажиллаж байна” гэсэн 3 гол үр дүнг онцлон тэмдэглэе.
- 2021 оны хувьд Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын зарласан ногдол ашгийн нийт дүн 150 тэрбум төгрөг байна. Үүнээс АПУ ХК-ийн зарласан ашиг 112 тэрбум төгрөг байгаа нь бахархууштай үр дүн юм.

Асуулт хариулт:

1. Хувьцаа эзэмшигч Ганболд: Нийт борлуулалтын орлогын хэдэн хувийг экспортын борлуулалт эзэлж байна вэ?
Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Нийт борлуулалтын 2% орчмыг эзэлж байгаа ч цаашид хурдацтай өсгөх дэд бүтцээ бэлдэж, бэлтгэлээ хангаж байна.
2. Хувьцаа эзэмшигч Хүрэлбаатар: 2022 онд зах зээлээс хувьцаа халааслах төлөвлөгөө бий юү? 2022 оны бизнес төлөвлөгөөнд архи, шар айргийн шил үйлдвэрлэх төлөвлөгөө бий юү? Шилээ эргүүлэн авч байгаа нь маш сайшаалтай хэдий ч шил хүлээн авах цэгийн тоог нэмэгдүүлэх хэрэгтэй.
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ариунсан: Хувьцаа эргүүлэн худалдан авах нөхцөл шаардлага үүсээгүй тул тийм төлөвлөгөө байхгүй.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Нийт 960 цэгээр шил цуглуулж байна. Бид шилээ буцааж тушаадаг соёлыг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна. Шил үйлдвэрлэх талаар бодож төлөвлөж байгаа ч 2022 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй. Энэ онд ложистикийн төв, GS25 сүлжээ дэлгүүр, сүүний салбар, экспортын үйл ажиллагаанд голчлон хөрөнгө оруулахаар төлөвлөсөн.

3. Хувьцаа эзэмшигч Дарханбаяр: Экспортын үйл ажиллагаанд Украины дайн, 0 ковид зэрэг олон улсын нөхцөл байдал хэр нөлөөлж байна вэ? GS25-д оруулж буй хөрөнгө оруулалт хэд вэ?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: ОХУ-ын согтууруулах ундаа лангуунаас авагдсан нь манайд боломж болж байна. Компани GS25 конвиниенс дэлгүүрийн сүлжээг эрхэлж буй Дижитал концепт ХХК-ийн 39%-ийг эзэмшиж байгаа ба 50% хүртэл эзэмшиж болох гэрээтэй.

4. Хувьцаа эзэмшигч Гантулга: Ерөнхийлөгч Хүрэлсүхийн зүгээс архитай тэмцэх уриалга гаргаж байна, үүнд ямар арга хэмжээ авч байна?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Архины хэрэглээ хүний нийгмийн бүх цаг үед байсан ба Компанийн хувьд 100 орчим жил энэ бизнест үйл ажиллагаа явуулж байгаа билээ. МУ-ын Ерөнхийлөгчийн зүгээс архины хатуулгийг бууруулах захирамж гаргасан. Үүнийг хэрэгжилт талаас нь нухацтай авч үзэх хэрэгтэй, сул градустай согтууруулах ундаа хэрэглэгчийн тоог өсгөх сөрөг үр дагавар гарах вий гэж болгоомжилж байна. Үйлдвэрлэгчийн зүгээс харахад хатуулгийг буулгах нь нийлүүлэгч талд ашигтай байж мэднэ. Ямартаа ч энэ үйл ажиллагаанд салбарын төлөөллийг оролцуулж хэлэлцэж буй нь том давуу тал болж байгааг дурдах нь зүйтэй.

5. Хувьцаа эзэмшигч Мөнх-Оргил: ОХУ-тай холбоотой геополитикийн байдал сайжрахгүй шинжтэй байна. Иймд тус улстай түншилж байгаа харилцаагаа цаашид хэрхэх бодолтой байна? 3-р сард явагдсан багцын арилжааны талаар тодруулга хийнэ үү.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Цаашид бизнесийн хүрээнд хамтын ажиллагаагаа үргэлжлүүлнэ.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Steppe Beverage компани буюу хөрөнгө оруулалтын сан багцын арилжаа хийсэн гэсэн мэдээлэл авсан, ханшийн өсөлтийн улмаас ашигтай гэж үзэж арилжаа хийсэн болов уу.

Хэлэлцсэн нь:

- 2. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох**

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг өөрчлөх болсон үндэслэлийг танилцуулахдаа “2017 оноос хойш Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажилласан Ө.Батбаяр Монгол Улсаас АНУ-д суух онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдаар томилогдож, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул түүний оронд О.Одбаярыг хувьцаа эзэмшигчийн хурал хүртэл түр томилсон байсан. Кумулятив аргаар сонгосон ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн үед ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь бүрэн эрхийг дуусгавар болгож, шинэ бүрэлдэхүүнийг сонгох хуулийн зохицуулалттай” хэмээв.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт байсангүй.

Хэлэлцсэн нь:

3. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 9 гишүүнийг сонгох

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: ТУЗ-ийн ердийн гишүүнд Шунхлай холдинг ХХК-аас нэр дэвшиж буй П.Батсайхан, Б.Батбаяр, Сергей Громов, Д.Миеэгомбо, Хайнекен Азиа Пасифик компаниас нэр дэвшиж буй Кеннет Чу, Сэн И-Ин, Steppe Beverage компаниас нэр дэвшиж буй Томас Холланд болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй Ё.Гэрэлчулуун, О.Одбаяр, Ж.Үнэнбат нарын товч намтрыг танилцуулав.

Асуулт байвал асууна уу гэхэд асуулт байгаагүй тул санал хураалтыг эхлүүлэв.

Санал өгөх зааврыг Тооллогын комиссын дарга Б.Онон танилцуулав. Санал хураалт явагдаж дуусав.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах:

Зөвшөөрсөн – 1,002,214,290 ширхэг хувьцаа буюу 99.98%

Татгалзсан – 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн – 210,557 ширхэг хувьцаа буюу 0.02%

2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох:

Зөвшөөрсөн – 999,274,647 ширхэг хувьцаа буюу 99.69%

Татгалзсан – 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн – 3,150,200 ширхэг хувьцаа буюу 0.31%

Дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

3. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох:

Ердийн гишүүд:

1. П.Батсайхан – 1,355,510,227 санал буюу 15.02%

2. Б.Батбаяр – 1,355,324,211 санал буюу 15.02%

3. Сергей Громов – 1,355,234,906 санал буюу 15.02%

4. Д.Миеэгомбо – 1,479,435,841 санал буюу 16.40%

5. Кеннет Чу – 1,197,647,189 санал буюу 13.27%

6. Сэн И-Ин – 1,197,526,688 санал буюу 13.27%

7. Томас Холланд – 1,079,564,191 санал буюу 11.97%

Хараат бус гишүүд:

1. Ё.Гэрэлчулуун – 508,743 санал буюу 0.01%

2. О.Одбаяр – 488,260 санал буюу 0.01%

3. Ж.Үнэнбат – 550,767 санал буюу 0.01%

Хурлын шийдвэр:

1. АПУ ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан доорх дүгнэлтийг баталсугай.
 - 1.1. АПУ групп компани 2021 онд тавьсан зорилтуудаа бүрэн биелүүлж, амжилттай ажилласан.
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгосугай.
3. АПУ ХК-ийн ТУЗ-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаагаар сонгосугай.

Ердийн гишүүн

1. П.Батсайхан
2. Б.Батбаяр
3. Сергей Громов
4. Д.Миезгомбо
5. Кеннет Чу
6. Сэн И-Ин

Хараат бус гишүүн

1. Ё.Гэрэлчулуун
2. О.Одбаяр
3. Ж.Үнэнбат

Ээлжит хурлыг хаав.

Хурал 16 цаг 10 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн

Нарийн бичгийн дарга

ХЯНАСАН:

Хурлын дарга



Ч.Ариунсан

Ц.Эрдэнэбилэг